



693

ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/410

Зуунмод

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль”-ийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 22 дугаар зүйлийн 22.1.7 дахь заалт, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5.3, 24.1, 29 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зуунмод сумын Номт 1-р багийн иргэн Б.Билгүүн нь Баянхошуу 3-р багийн Хөтөл 8-ын 806 тоот хашаанд Эдильбай үүлдрийн хээлтүүлэгч 39 толгой, хээлтэгч 5 толгой нийт 44 толгой амьд хонин сүргийг Оросын холбооны улсаас оруулж ирж байгаа тул 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс хойш 21 хоногийн хугацаанд хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2.Импортоор орж ирсэн хонин сүргийн ашиглалт, арчилгаа маллагаа ашиглалтын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга (Б.Туул), Баянхошуу багийн Засаг дарга (Ш.Цэндсүрэн) нарт, сүргийн эрүүл мэнд, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хяналт тавьж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн хяналтын улсын байцаагч (Б.Сарантуяа) нарт тус тус даалгасугай.

3.Импортоор орж ирсэн хонин сүргийн арчилгаа маллагааг мэргэжлийн байгууллагын зөвлөсөн горимын дагуу явуулж, 21 хоногийн хугацаанд бэлчээрт гаргалгүй байран маллагаанд байлгаж, малын эмчийн хяналтан дор тэжээллэг арчилгааг явуулж, хамтран ажиллахыг иргэн (Б.Билгүүн) –д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.САРАНГЭРЭЛ

